



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах адил тэгш боломж, хөгжил, хамгаалал

Илтгэгчид: Д.Одгэрэл (Ph.D)
Г. Батцэнгэл (Ph.D)
Ч. Байгалмаа (Ph.D)

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Хөгжлийн бэрхшээлтэй хүн: Бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ (НҮБ, ХБХ-ий эрхийн тухай конвенци, 2006).

Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүд: Хөгжлийн бэрхшээлтэй, хараа хяналтгүй, ажил эрхэлдэг, алслагдмал болон нүүдэлчин өрхийн, хэл соёл ба үндэсний цөөнхийн, шашин шүтлэг зэргээс үл хамааралтай, ялгаварлан гадуурхагдсан... хүүхдүүдийг хэлнэ (Саламанкагийн тунхаглал, 1994).

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Тусгай хэрэгцээт боловсрол: Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдийн хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд нь тулгуурлан боловсрол эзэмшүүлэх үйл явц юм.

Тэгш хамруулах боловсрол: Ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халан суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар, онцлог шинж, сурах хүсэл эрмэлзлэлийг нь хүндэтгэн үзэж бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэгдсэн тасралтгүй үйл явц юм (Женев, ОУ-ын Боловсролын бага хурал, 2008).

Тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол,
бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих
(Incheon, 2015)




ТЭГШ БАЙДАЛ


ТЭГШ БОЛОМЖ

БОДИТ БАЙДАЛ


Ялгаварлах




Тусгаарлах



Интеграцчилах




Тэгш хамруулах




ХБХ боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй өнөөгийн байдал

Нийт ХБХ-ийн тоо
32,000




ЕБС-д сурч буй ХБХ-ийн
тоо 7279



23,122

хүртээмж



ХБХ-ийн суралцах адил тэгш боломж ба ололт амжилт

- ОУ-ын гэрээ конвенци
- ХБХ-ий эрхийн тухай хууль (2016)
- ХБХ-ий эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр (2017)
- “ТХБ шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл” (Жайка ОУБ, 2015-2019)
- Багш нарыг чадавхжуулах сургалт, “ТХБ-ыг дэмжих төв” (Койка ОУБ, НБГ)
- “Тэгш хамруулах боловсролын үйлчилгээг дэмжих төсөл” (НҮБ-ын Хүүхдийн сан, МУ-ын ЗГ)

ХБХ-ийн суралцах адил тэгш боломж ба ололт амжилт

- “Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийг дэмжих” судалгаа (МУБИС, Нагоя ИС-ийн хамтарсан “Хүүхдийн хөгжлийг дэмжих төв”, 2013)
- ТХБ-ын тэнхим (МУБИС-ийн БоСС, 2017-12 сар)
- ТХБ-ын багш мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөр (МУБИС)
- ТХБ-ын багшийн 1 жилийн хөрвөх анги (МУБИС, 2013/2015)
- Заавал судлах болон сонгон судлах хичээл (МУБИС, БС, СӨБС, Бусад)
- Тусгай сургуульд хүүхэд бүрт үдийн хоол
- Хот хөдөөгийн ЕБС-ийн зарим сургуульд ХБХ-тэй ажиллаж буй сайн туршлага (Хөвсгөл, Өмнөговь гэх мэт)

Тулгамдаж буй нийтлэг асуудал

Нэгдсэн
ойлголт

Хандлага,
дэмжлэг

Эрх зүйн
зохицуулалт

Судалгаа
шинжилгээ

Зорилтот
санхүүжилт

Бүтэц,
зохион
байгуулалт

Мэргэжилт-
ний дутмаг
байдал

ЕБС-ийн хүрээнд тулгамдаж буй асуудал

Хүүхэд бүр өөрийн харъяалагдаж буй нутаг дэвсгэртээ боловсрол эзэмших ёстой боловч бодит амьдрал дээр хэрэгжихгүй байна.

Багшийн
хандлага

Сургалтын
хөтөлбөр

Сургалтын
хэрэглэгдэхүүн


Сургуулийн
орчин
нөхцөл

Сургалтын арга
зүй

Үнэлгээ



Тусгай сургуулийн хүрээнд тулгамдаж буй асуудал



Тулгамдаж буй асуудал

“Хөгжлийн
бэрхшээлтэй
суралцагч”

Тусгай хэрэгцээт
боловсрол
шаардлагатай
хүүхэд

Чадварын
өөрчлөлттэй
хүүхдүүд


АНУ-ын тусгай боловсролын тухай хуулиар нь аутизм, хараа-сонсгол, сонсгол, хөгжлийн хоцрогдол, зан төрхийн эмгэг, оюуны бэрхшээл, хавсарсан бэрхшээл, тулгуур эрхтний бэрхшээл, бусад эрүүл мэндтэй холбоотой эмгэг, суралцахуйн бэрхшээл, хэл ярианы бэрхшээл, тархины гэмтэл зэрэг ангилалд тодорхойлж тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ үзүүлж байна (IDEA, 2004).

Тулгамдаж буй асуудал


“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс нь 0-16 насны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавина”.
(Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоол)

Хөгжлийн бэрхшээлтэй **хүүхдүүдийн боловсролын тусгай хэрэгцээг илрүүлэх, хөгжлийг үнэлэх, сургалтаар дэмжих** тогтолцоо байхгүй байна. Тусгай боловсрол шаардлагатай хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн ангиллыг хүүхдийн хөгжлийн үнэлгээний судалгаанд суурилж тогтоох, дэмжих /МУБИС, Нагоя Их Сургуулийн хамтарсан “ХХДТ” –ийн үйл ажиллагааны загвар/

Асуудлыг шийдвэрлэхэд баримтлах зарчим, арга зам



Тэгш хамруулах боловсрол



Асуудлыг шийдвэрлэх арга зам – Бодлого боловсруулах түвшинд

- Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллага нь тэгш хамруулах боловсролын бодлого боловсруулж, тэгш хамруулах соёлыг бий болгож хэрэгжүүлэх
- ОУ-ын баталгаатай аргачлалын дагуу үндэсний хэмжээнд ХБХ-ийн тархалтын судалгааг хийж, тусгай хэрэгцээг тодорхойлох, ангиллыг тогтоох, хуулиар баталгаажуулах
- Тусгай хэрэгцээт болон тэгш хамруулах боловсролын тухай хууль шинээр боловсруулах, бусад хуулийн зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулах
- Эцэг эх, олон нийт, багш, удирдах ажилтнуудын хандлагыг өөрчлөх, дэмжлэг бий болгох нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах

Бүх сурагчид өөрийн амьдардаг орон нутагтаа **ЕБС-д** тэгш боломж бүхий, чанартай боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх

- ЕБС-ийн багш нарыг чадавхжуулах сургалтад хамруулах
- Тусгай сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг шинэчлэн сайжруулах
- Тусгай хэрэгцээтэй сурагчийн ахиц хөгжлийг үнэлэх үнэлгээний журам боловсруулах
- ХБХ-ийн тоогоор авч буй хувьсах зардлыг зөв оновчтой зарцуулах (ГСТ-ийн дагуу ажиллаж байгаа багшийн урамшуулал, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, ном, гарын авлага, бусад шаардлагатай материал)
- Анги зохион байгуулалтыг оновчтой, үр дүнтэй байдлаар хийх (УБС-ийн дэргэд тусгай анги, нөөц ангитай болох)
- Ерөнхий боловсролын бүх сургуульд тусгай хэрэгцээт боловсролын багш, туслах багш ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх

Асуудлыг шийдвэрлэх арга зам- Тусгай сургуульд

- ТС-ийн багш нарыг чадавхжуулах сургалтад хамруулах
- Хүүхдийн онцлогт тохирсон ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх (ГСТ), материаллаг орчинг бүрдүүлэх
- Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Дараагийн шатны шилжилтийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдийг сургах
- Анги удирдсан болон туслах багш нар мэргэжлийн сургалтад хамрагдсан байх
- Мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх төв болгон үйл ажиллагаагаа өргөжүүлэх
- Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын бусад байгууллагуудтай хамтран ажиллах

Асуудлыг шийдвэрлэх арга зам – Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын түвшинд

- Их дээд сургуулиудын багш нарыг чадавхжуулах, мэргэшүүлэх
- Багш бэлтгэдэг улсын болон хувийн их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт “Тусгай хэрэгцээт боловсрол”, “Тэгш хамруулах боловсрол” хичээлийг заавал судлах хичээлээр оруулах
- НБГ-ын “Тусгай хэрэгцээт боловсролыг дэмжих төв”, МУБИС-ийн “ХХДТ”-ийн үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, онлайн сургалт зохион байгуулах
- Бүх шатны боловсролын байгууллагуудын удирдах ажилтан, багш нарт зориулсан “Тусгай хэрэгцээт боловсрол”, “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын ойлголтыг түгээх, сургалт зохион байгуулах

Ашигласан ном зүй:

- БСШУЯ (2017) Боловсролын салбарын 2016-2017 оны хичээлийн жилийн статистик мэдээллийн эмхтгэл, Эдмаркет ХХК, УБ
- БСШУЯ Г(2007) “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр” –ийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ Мөнхийн үсэг ХХК, УБ
- Б.Насанбаяр, Д.Одгэрэл, Г. Битцэнгэл, Ч. Жаргал, Р. Туяа,(2015) Тэгш хамруулан сургах багшийн боловсрол, зөвлөмж, ЮНЕСКО, Японы Итгэлцлийн сан, Адмон принт, УБ
- Жаргалмаа, Ц. Болд (2017) "Хүүхдэд тулгарч байгаа эрсдэл, бэрхшээлийг ерөнхий боловсролын сургууль дээр илрүүлэх нь", Хараат бус судалгааны хүрээлэн, “Хөгжлийн бэрхшээл судлал нь салбар дундын шинжлэх ухаан болон нь” ЭШХ-ын эмхэтгэл (84-91)УБ
- МУБИС, Нагоя их сургуулийн хамтарсан төслийн баг (2017) “Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай сурагчдыг дэмжих” төслийн тайлан, Содпресс, УБ
- НУБ (2006) “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенци”-д нэгдэн орж 2016 НУБ-ын Соёл, шинжлэх ухаан, боловсролын байгууллага (2015) Инчоно тунхаглал НУБ-ын Соёл, шинжлэх ухаан, боловсролын байгууллага (1994) Саламанкагийн тунхаглал
- УИХ (2016) “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль